

ОРЧУУЛГЫН БУЛАН



ЗҮҮН АЗИ БҮРЭЛДЭН ТОГТСОН НЬ: ЧИН УЛСЫН ТӨГСГӨЛ ҮЕИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

*Рунэ Сварвэруд***

Жоу улсын үед анх төрт улс үүсэх үеэс л Зүүн Ази дахь улс орон, үндэстнүүд өөрийн гэсэн онцлогоо бүрэлдүүлсээр иржээ. Хятадын эртний Цинь улсаас өмнө ч гэсэн олон улсын харилцааг зохицуулсан нарийн хууль журам оршин байсан гэдгийг 1860-аад онд Тунвэньгуань (Гадаад, хэл соёлын сургууль)-д орчуулагдсан олон улсын эрх зүйн сурах бичгүүд мөн Мартин (1882)²⁸⁶, Кэйширо Ирие (1967), Ричард Волкер (1971) нарын бүтээлээс харж болох юм. Энэхүү систем аяндаа Цинь, Хань улсын үед төв Хятадын хойд хэсгээр бий болсон нэгдсэн нэг захиргааны улмаас үгүй болсон ажээ. Тан улсын үед Зүүн Азид бий болсон Хятадын улс төр, соёлын нөлөөний үрээр тус бүс нутаг дахь улс хоорондын харилцаа Хятадын эзэн хаан ба түүний бүрэн эрхийн дор буй улсууд гэсэн хүрээнд явагдах болсон юм. Ази тив дэх улс хоорондын харилцаа үндэстнүүдийн өөрийн гэсэн онцлогийг хадгалж, улс хоорондын харилцааг харилцан тэнцвэржүүлсэн хүчний онцгой системийг бий болгосон байна. Зүүн Ази XIX зуунд Өрнөдийн улс орнуудын тэлэлтэй тулгарах үед Хятад гадаад ертөнцөөс өөрийгөө тусгаарлаж, түгшүүрт автсан орон болж хувирсан бөгөөд сюзерен ба вассал улсууд гэдэг хүрээнд улс орнууд харилцдаг гэсэн ойлголттойгоор энэхүү зууныг элээжээ. Европын орнуудтай анх удаа өргөн хэмжээгээр харилцаж эхэлсэн ч Зүүн Ази дахь улсуудын харилцааны талаарх Хятадын албан ёсны болоод эрдмийн хүрээний үзэл, байр сууринд бараг л өөрчлөлт орсонгүй. Бүрэн эрхийн зарчимд суурилсан Европын хүчний тэнцвэрийн системээр дамжуулж улс хоорондын харилцааг тайлбарлах гэсэн арга зүй XIX зууны дунд үеийн Хятадын орчуулгын бүтээлд л дөнгөж үзэгдэж эхэлсэн байна. Харин улс хоорондын харилцааны талаарх хууль, зохицуулалтын тайлбар ба түүний Зүүн Азийн практикт буусан хэлбэр XIX зууны төгсгөл буюу тус бүс нутгийн хүчний харилцаанд огцом өөрчлөлт гарах болсон үед л илүү ойлгомжтой болж ирсэн ажээ. Энэхүү их өөрчлөлтийн үрээр Зүүн Ази дахь уламжлалт улс үндэстний онцлог, харилцаа орвонгоороо эргэжээ.

Чин улсын төгсгөл үед Хятадын эрдмийн хэлэлцүүлгийн хүрээнд олон улсын харилцааг ойлгох гэсэн үйл явцад олон улсын эрх зүй судлал ямар арга замаар бий болсон тухай, мөн Зүүн Ази дахь улс хоорондын харилцааны энэхүү чухал үед Хятадын олон улсын харилцааны талаарх ойлголт, үндэсний онцлог бүрэлдэн тогтоход Өрнөд судлал (хихуе) ямар үүрэг гүйцэтгэсэн зэргийг авч үзэхээс гадна

* Ослогийн их сургуулийн Соёл судлал, Дорно дахины хэл шинжлэлийн тэнхмийн профессор

* Орчуулсан: Б.Идэрбат - Австралийн Монаш Их Сургуулийн (Monash University) магистрант Email: iderbat2002@hotmail.com

²⁸⁶ The text was later expanded and published in various formats in English, French and Chinese in the 1880s and 1890s.

олон улсын эрх зүй судлал Хятадад нэвтэрснээр тус улс олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэг, байр суурийн талаарх уламжлалт ойлголтоо халж, “улсуудын гэр бүл”-ийн нэгэн гишүүн гэж ойлгох болсон гэдгийг энэхүү өгүүллээр харуулахыг оролдоно. Олон улсын эрх зүй Чин улсын олон улстай явуулах бодлого, дипломат ажиллагаанд хэрхэн нэвтэрсэн тухай энэхүү өгүүллээр авч үзэхийн оронд²⁸⁷ эдгээр эрх зүйн ойлголтыг хэрхэн хүлээж авч, орчуулсан, түүний үрээр ямар хэлэлцүүлэг Чин улсын эрдмийн хүрээллийн дунд өрнөснийг задлан шинжлэх юм. Иймээс “олон улсын харилцааны талаарх ойлголт”, “дэлхийн чиг хандлага” гэдэг зүйлс нь Чин улсын төгсгөл үеийн эрдмийн хүрээний ойлголт хандлагад хэрхэн нөлөөлж байсан гэдгийг харуулж буй хэрэг болно.

Юуны өмнө олон улсын эрх зүй судлал гэх ойлголтын тухай товч хэдэн зүйл авч үзье. 1842 оны Хар тамхины дайны үр дүнд байгуулагдсан Нанжины гэрээний дараагаар Хятадад Өрнөдийн олон тооны ном, бүтээл орчуулах үед бий болсон Өрнөдийн эрх зүйн системийн тухай мэдлэгийг хэрхэн нэвтрүүлсэн тухай авч үзэх гэж буйг гадарласан биз ээ. Олон улсын эрх зүй нь эрх зүй судлалын хувьд Хятадад нэвтэрснээр маш чухал нөлөөг тус улсад үзүүлсэн гэдгийг уг өгүүлэл харуулахыг зорих юм. Олон улсын эрх зүй нь эрүүгийн хууль, иргэний хууль, үндсэн хуулийн эрх зүйн нэгэн адил хууль, эрх зүйн шинжлэх ухааны зөвхөн нэг салбар юм. Олон улсын эрх зүйд бусад салбар ухаанаас нэг чухал ялгаа оршдог нь дотоодын эрх зүйн системд байдаг хууль сахиулах систем гэдэг зүйл байдаггүй. Олон улсын эрх зүйн зарим нэг хэсгийг НҮБ, Нидерландын Гаг хотноо байрлах Олон улсын шүүх, Олон улсын эрүүгийн шүүх хамгаалж байгаа гэж хэлж болно. Гэхдээ XIX зууны сүүл XX зууны эхэн үед ийм систем байгаагүй гэдгийг та бүхэн мэднэ. Тухайн үед улс хоорондын харилцааг зохицуулахын тулд голдуу Европын улсуудын бий болгож харилцан тохиролцсон дүрэм журмын системийг хэрэглэж байв. Хуулийг сахиулах ганц арга нь олон улсын эрх зүйд заасан дүрэм, журмыг хэрэгжүүлээгүй улсын эсрэг дайн хийх явдал байжээ. Үүнийг заримдаа “зүй ёсны дайн” гэж нэрлэдэг байв. Анх бий болсон цагаасаа хойш олон улсын эрх зүй нь Европын улсуудын систем үүсч хөгжих нэг гол хүчин зүйл болсон юм. Мөн тодорхой дүрэм журмын хүрээнд хоорондын харилцаагаа зохицуулахын тулд “иргэншсэн” гэх христийн шашинтай өрнөдийн орнуудын харилцан тохиролцсон нэг арга зам байв. Энэхүү хүрээлэл буюу “гэр бүл”-д багтаж байсан улсууд Европоос бусад газарт буй христийн шашингүй орнуудыг нэгэн адил эрх бүхий гишүүн гэж үздэггүй байжээ. Америк тив дэх өөр шашинтай иргэд, Ази, Африкийн улсуудыг “иргэншээгүй”, эсвэл сайндаа л “хагас иргэншсэн” гэж үздэг байсан тул тэд “гэр бүл”-ийн гишүүдийн нэгэн адил эрх, ямба эдлэх боломжгүй байв. Иймээс олон улсын эрх зүй нь хөгжлийн эхэн шатандаа бусад улсыг хүрээндээ хүлээн авахын оронд Ромын эзэнт гүрэн нуран унасны дараах 1648 оны Вестфалийн гэрээний үр дүнд бий болсон улсуудын харилцааг тодорхойлсон онолын хүрээний систем байсан гэж үзэхээс өөр аргагүй юм. Ийм ч учраас “иргэншээгүй”, “хагас иргэншсэн” гэх маягаар ангилж,

²⁸⁷ Thoroughly researched and presented by a number of both Chinese and western scholars in works such as: Fairbank (1953); Gong (1984); Hsu (1960); Hughes (1968); Lin Xuezhong (2010); Mancall (1971); Morse (1971); Qi Qizhang (2001); Tian Tao (2001); Wang Ermin (1998); Wang Tieya (1991); and Zhang (1992).

өрнөдийн олон улсын эрх зүйн гадна талд байсан улсыг колоничлох нэг арга зам болгон ашиглаж байжээ. Орчин үеийн олон улсын эрх зүйн судлалыг хөгжүүлсэн улс төрийн философичдийн гол төлөөлөгчдийн нэг нь Нидерландын Хюго Гроций (1583-1645) Америк тивийг иргэншүүлж, колоничилсныг онолын үндэслэлтэйгээр хамгаалсан нь үүний нэг нотолгоо гэж Ричард Так онцолсон юм (Tuck 1999).

Иймээс олон улсын эрх зүй нь хөгжлийн эхэн шатандаа цэвэр хууль эрх зүйн систем гэхээсээ дундад зууны үеийн Европын түүх, Европын улсуудын тэлэлт, Ази, Африк, Америк тивийн колоничлолтой нягт холбоотой соёлд тулгуурласан олон улсын систем байжээ гэж дүгнэхэд буруудахгүй юм. Үнэхээр ч олон улсын эрх зүй нь анхан шатандаа улс хоорондын худалдаа, дипломат харилцаа, хилийн асуудал, эрх мэдлээ харилцан зөвшөөрөх хэмжээний тохиролцооны хүрээнд илэрдэг байв. Европ болоод бусад газарт (Жоугийн үеийн Хятадын улсуудын хооронд) энэхүү харилцааг албан ёсоор бичмэл гэрээ, хэлэлцээрээр зохицуулдаг байжээ. Эдгээр гэрээ нь олон улсын эрх зүйн анхан хэлбэр юм. Хожим Европт хоёр талын харилцааг зохицуулсан гэрээ нь хоёр ба түүнээс дээш тооны талыг оролцуулах болж, хөрш улсуудын философи, тэр байтугай ёс суртахуун, шашин зэрэгцэн орших харилцааг зохицуулдаг систем болон хувирсан байна. Энэхүү системийг хөгжүүлэхэд Хюго Гроций, Томас Хоббс (1588-1679), Самуэл Пуфендорф (1632-1694), Шарль Монтескье (1689-1755), Кристиан Вольф (1679-1754), Эмэрих де Ваттел (1714-1767) гэх мэт олон тооны улс төрийн философичид хувь нэмрээ оруулсан юм. Иймээс олон улсын эрх зүй нь эрх зүйн систем шиг мөртлөө өрнөдийн улс хоорондын харилцааны практик, өрнөдийн философичдийн онолын сэтгэлгээнээс урган гарсан зүйл байжээ гэж хэлэхэд хилсдэхгүй. Европын агуулга бүхий олон улсын эрх зүйг иймээс түүх, хууль, иргэнших нэг арга зам, улс төрийн философи, дипломат практик гэж хэлж болох юм.²⁸⁸ Цаашлаад олон улсын эрх зүй Хятадад нэвтрэх үедээ тус орны түүх, эрдмийн түүх, Азийн улсуудын харилцаа, Зүүн Азийн улсуудын үндэсний онцлог бүрдэх нэг хэсэг нь болсон гэдгийг уг өгүүлэл харуулах юм. Чин улсын төгсгөл үед олон улсын эрх зүй нь Өрнөд судлал гэх судлагдахууны нэг хавсарга болон орж ирсэн агаад тухайн үеийн Хятадын сэхээтнүүдийн ертөнцийг үзэх үзэлд маш чухал нөлөө үзүүлжээ. Олон улсын эрх зүй нь өнөөдөр ч гэсэн олон улсын талаар баримтлах Хятадын чиг хандлага, дипломат ажиллагаа, Зүүн Азийн улсуудын харилцааны нэг чухал нэг хэсэг хэвээр байгаа. Энэхүү үйл явц XIX зууны сүүл үед хүчний харилцаа өөрчлөгдөхтэй зэрэгцэн эхэлсэн юм. Мөн уг өгүүллээр орчин цагийн Хятад хэлэн дэх олон улсын эрх зүйн үгсийн сангийн үүсэл Чин улсын төгсгөл үеийн орчуулга, хэлэлцүүлгээс гаралтай гэдгийг харуулна.

²⁸⁸ Debates on these questions have recently often been related to the idea of a clash between civilizations forwarded by Samuel Huntington in his book *The Clash of Civilizations and the Remaking of World Order* (Huntington 1996). See also Liu (2004).

Олон улсын харилцааны талаарх ойлголт

XIX зуунд Зүүн Азийн улсуудын үндэсний онцлог хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлахдаа дэлхийн чиг хандлага гэдэг зүйл Хятад хэлэнд ямархуу утгаар буудгийг авч үзье. Эртний Хятад буюу Жоугийн үед олон тооны том, жижиг улсуудын хүчний тэнцвэр, харилцааг зохицуулдаг систем оршин байсан тухай миний бие өмнө нь дурдсан. Чин улсын төгсгөл үеэс хойш мөн адил олон тооны Өрнөдийн болоод Хятадын судлаачид Жоугийн үеийн Хятадад олон улсын харилцааг зохицуулсан эрх зүйн систем үнэхээр байжээ гэж нотолсоор ирсэн юм. Цинь улсын өмнөх үеийн Хятадын эртний Күнз болоод Даогийн уламжлалын философичдын үзэл санааг зарим судлаачид авч үзээд олон улсын харилцааны талаарх Хятадын бие даасан үзэл санаа байжээ гэж үзсэн байдаг. Чин улсын төгсгөл үед өөрчлөлтөд орсон Хятадын олон улсын харилцааны талаарх ойлголтод дөрвөн төрлийн чиг хандлага нөлөө үзүүлжээ. Зүүн Ази дахь уламжлалт улс төр, соёлын дэг журмын анхны хэлбэрийн талаар уг өгүүллийн эхэнд дурдсаныг санаж байгаа байх. Үүний эхнийх нь эзэн-албатын систем юм. Зүүн Ази дахь олон орон Хятадын эзэн хаанд алба барьж, дээд эрхийг нь зөвшөөрдөг байв. Ихэнх хөрш орнууд нь Хятадын эзэн хаанд тогтмол алба барьж, бараалхдаг байсан энэхүү тогтолцоог эзэн-албатын систем гэж ойлгодог. Хятадын эзэн хаантай ямархуу статусын хүрээнд харилцаж байгаагаас тухайн хөрш улсын айлчлалын хэлбэр хамаардаг байсны сацуу Хятадын нийслэл, эзэн хаантай газар зүйн хувьд хэр ойрхон байхаас мөн хамаардаг байжээ. Иймээс уг системийг нэг төвтэй систем гэж үзсэн тохиолдол бий (Wong 1997; Wills 2005; Pomeranz and Torik 2006). Орчин цагийн ойлголтоор уг системийг сюзерен-вассал буюу вассал улс нь сюзерен улсынхаа дээд эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг гэсэн утгатай дүйх юм. Хятадын эзэнт гүрэнтэй хийх худалдааг уг уламжлалт систем мөн зохицуулдаг байсан гэсэн үг. Хятадын тэр дундаа Мин улсын худалдааны харилцааны тухай хэд хэдэн судалгаагаар уг системийн гадуур хувийн шинжтэй худалдаа хийгддэг байсан бөгөөд энэ нь тэс ондоо зарчимд тулгуурладаг байсан ажээ. Өөрөөр хэлбэл энэхүү хувийн худалдааны систем албатын системтэй зэрэгцэн оршиж байсан гэж хэлж болно. Жоугийн үеийн улсуудыг тооцохгүйгээр орчин цагийн Хятад бий болохоос өмнө байсан хоёр төрлийн ийм систем Зүүн Ази дахь улсуудын харилцааг тодорхойлдог байжээ.

Өрнөдийн орчин цагийн мэдлэгийг орчуулж нэвтрүүлэх үед хоёр төрлийн харилцан адилгүй чиг хандлага Хятадад оршин байжээ. Эхнийх нь тухайн үедээ хамгийн нөлөөтэй буюу социаль Дарвинизм гэгддэг нийгэм-улс төрийн эволюци ба дэвшлийн философи байв. Хоёр дахь нь энэхүү олон улсын эрх зүй байсан юм. Хувь хүн, олон түмэн (qun) хүмүүсийн хоорондын харилцааны нэгэн адил улсуудын хоорондын харилцаа өрсөлдөөн дунд явагддаг гэж Хятадын онцлогтой социаль Дарвинизм үздэг байв. Иймээс энэхүү ертөнц нь амь гарахын төлөөх тэмцэл ба хамгийн хүчтэй, хамгийн шалгарсан нь амьд үлдэх “эрхтэй” гэж үздэг байсан юм. Энэхүү үзэл санаа тухайн үедээ Японы нөлөөгөөр нэлээд хүчтэй түгсэн байсан ба Хятадын сэтгэгчид болох Лян Цичао (1873-1929), Янь Фу (1854-1921) нар дэмждэг байжээ. Иймдээ ч тухайн үеийн Хятадад нийгмийн онолын чухал арга

зүй болж байв (Pusey 1983; Dikotter 1992). Уг онолоор улс хоорондын харилцаа, амьд үлдэх гэсэн стратеги дотроос хүч гэдэг зүйл л хамгийн чухал байв. Ийм ч учраас Чин улсын төгсгөл үед олон улсын харилцааг ойлгоход энэхүү онол итгэл үнэмшил төрүүлэхүйц байжээ. Хар тамхины хоёр ч удаагийн дайнаар Хятад орон Өрнөдийн өмнө сөхөрсөн байсан тул Хятадын улс төр, цэрэг, эдийн засгийн хүчийг нэмэгдүүлж байж улс төрийн нэгжийн түвшинд өөрийгөө хамгаалж, өөрсдөө улсаа захирах боломжтой болно гэж үздэг байв. Мөн энэхүү онолоор Хятадыг хүчирхэг, өрсөлдөөнд шалгарахын тулд олон улсын эрх зүйг нэг арга хэрэгсэл ашиглах ёстой гэж байв. Харин олон улсын эрх зүйг баримтлагчдын хувьд Хятадын олон улсын харилцааны талаарх чиг хандлага тэс өөр байр суурь гаргаж өгсөн юм. Хэрэв Хятад орон “улсуудын гэр бүл”-д нэгдэн орох хүсэлтэй бол бусад улсын нэгэн адил ижил эрхтэй, бүрэн эрхтэй улсын хувиар хандах хэрэгтэй. Чингэж чадах юм бол заавал цэрэг, эдийн засаг, улс төрийн хүчийн хувьд шалгарсан байх шаардлагагүй гэсэн баримтлал байв. Хэрэв Хятад бусад улсыг бүрэн эрхт улсууд гэж хүлээн зөвшөөрвөл өөрийнх нь бүрэн эрхийг бусад нь зөвшөөрөх тул иргэншсэн гэх улсууд эгнээндээ нэгтгэнэ. Улмаар Хятад олон улсын эрх зүйн хүчний тэнцвэр гэх зарчмын хүрээнд улс гэдэг эрхээ эдлэх боломжтой болно гэж үздэг байжээ. Энэхүү чиг хандлага социаль Дарвинизмын онолоос тэс ондоо тэр байтугай бүр уг хандлагыг эсэргүүцсэн шинжтэй байв. Гэхдээ хоёр чиг хандлага хоёулаа Хятадын байр суурийг бэхжүүлэхэд олон улсын эрх зүй тусална гэж үздэг байжээ. Чин улсын төгсгөл үеийн эрдмийн хэлэлцүүлгийг харахад олон улсын эрх зүйн чиг хандлага сэхээтнүүдийн дунд аажмаар хүчтэй болж ирсэн байна. Социаль Дарвинизмыг хүчтэй дэмжигч Лян Цичао хүртэл XX зууны эхэн үед олон улсын эрх зүйг нэвтрүүлэх хэрэгтэй хэмээн аажмаар ярих болжээ.

Олон улсын эрх зүй нэвтэрч эхэлсэн нь

Олон улсын эрх зүйг юу гэж тайлбарлахаас хамаарч Хятадад анх хэдийд уг эрх зүй нэвтэрсэн хугацаа өөр байх юм. Өмнө нь Жоу улсын үед олон улсын эрх зүйн анхан шатны хэлбэр оршин байсан гэдгийг дурдсан билээ. Хэрэв тэр үеийг тооцохгүй гэвэл улсын хувиар худалдаа, хилийн асуудлыг хөрш улстайгаа бичгийн хэлбэрээр гэрээ байгуулж шийдсэн анхны тохиолдол бол Оростой 1689 онд Нерчинскт, 1727 онд Хиагтад байгуулсан гэрээнүүд болох юм. Европт тухайн үед албан ёсоор нэвтэрч эхлээгүй байсан олон улсын эрх зүйн практик энэхүү хоёр гэрээнд туссан байдаг.²⁸⁹ Хятадын эзэн хаан гадаад улстай гэрээ байгуулахаас аргагүйд хүрсэн хоёр дахь том түүхэн үйл явдал бол Хар тамхины нэгдүгээр дайны дараагаар байгуулсан Нанжины гэрээ юм. Гэхдээ энэхүү гэрээнд ч олон улсын эрх зүйн гол нөхцөл болох харилцан биенээ хүлээн зөвшөөрөх болон үндэсний бүрэн эрхт байдал тусгагдаагүй юм. 1842 оны Нанжины гэрээгээр олон улсын эрх зүйд байдаг бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөлгүйгээр байгуулсан тул уг гэрээ нь “тэгш бус” гэрээ гэж нэрлэгдэх нь зүйн хэрэг. Тухайн үед олон улсын эрх зүйн онол,

²⁸⁹ It has been suggested that China encountered the principles of international law already through Jesuit missionaries such as Martin Martini (1614–1661) and through negotiations with the Dutch in the middle of the 17th century. None of these claims have, however, been substantiated by textual evidence.

практик Хятадад хараахан нэвтрээгүй байсан тул Өрнөдийн улсууд олон улсын эрх зүйд тусгагдсан эрхийг Хятадад өгөх сонирхол байгаагүй. Хэрэв ийм эрхийг олж авбал Хятадтай хийх худалдааны ашиг сонирхлыг хөндөж магадгүй гэж Өрнөдийн орнууд болгоомжилж байв.

Хятадын ашиг сонирхолд харш энэхүү хандлагыг анх Лин Зесю (1785-1850) түүний хамтран зүтгэгч Вэй Юань (1794-1856) нар Хар тамхины дайны дараахан олж анзаарсан байдаг. Лин Зесю нь Гуанжоуд байсан Америк эмнэлгийн төлөөлөгч Петер Паркер (1804-1888)-тай холбоотой байсан ажээ. Лин зуучлагчдаар дамжуулж Швейцарийн хуульч Эмэрих де Ваттелын бичсэн “Үндэстнүүдийн хууль” номыг Паркераар орчуулуулахыг хүсч байсан байна.²⁹⁰ Энэхүү ном Вэй Юаний 1844 онд бичсэн “*Хайгуо тужи*”-гийн анхдугаар хэвлэлтэд дурдагдаагүй ч 1847 оны нэмэн засварласан хэвлэлтэд орж ирсэн ажээ. *Хайгуо тужи*-гийн хоёр өөр хувилбарт Ваттелын хэд хэдэн өгүүлбэр орсон байгааг харж болох бөгөөд тус бүрийг нь Паркер болон Юань Дэхуй нар оруулжээ. Энэхүү хоёр орчуулга хоорондын тэс ондоо, өөр үгсийг ашигласан байхын сацуу Паркер анхлан буулгаж, хожим Юань Дэхуй уг орчуулгыг янзалж, Хятад уншигчдад ойртуулан буулгасан байх магадлалтай юм. *Хайгуо тужи*-д яагаад энэ хоёр өөр орчуулгыг оруулсан нь тодорхойгүй юм.²⁹¹ 1840-өөд онд бичгийн Хятад хэлэнд олон улсын эрх зүйн ойлголтыг буулгахад ямархуу хүндрэлтэй тулгарч байсан гэдгийг энэхүү орчуулга харуулж байгаа юм. Энэ хоёр орчуулгаар тухайн үеийн Хятад хэл олон улсын эрх зүйн онол, ойлголтыг орчуулах тохирсон нэр томъёогоор дутмаг байсан гэдэг нь харагдаж байна. Юань Дэхуй тухайлбал *daoli* гэдэг нэр томъёог эрх гэж орчуулснаас үзэхэд Хятад хэлэнд олон улсын эрх зүйн тодорхой хэллэгүүд буухад хүндрэлтэй байжээ. *Хайгуо тужи*-д дурдагдсан Ваттелын хэдэн өгүүлбэрээс олон улсын эрх зүйн талаар ойлголт авах бараг боломжгүй юм. Олон улсын эрх зүйн хожмын орчуулга, бичгийн хэлэлцүүлгээс харахад Ваттелын бүтээлийн нөлөө Хятадад тун бага байжээ гэдэг нь харагдсан байна.

Тухайн үеийн Хятадад олон улсын эрх зүйн онол, практикийн хувьд нэвтэрсэн ч гэлээ олон улсын хамтын нийгэмлэгт Хятадын эзлэх байр суурь, Зүүн Ази дахь улсуудын үндэсний онцлогийн өөрчлөлтөд онцгой нөлөө үзүүлж чадаагүй байна. Энэхүү үйл явцыг эхлүүлэхийн тулд олон улсын эрх зүйг зохион байгуулалттайгаар бүрэн хэмжээнд нэвтрүүлэх шаардлагатай байв. Энэхүү үйл явц хориод жилийн дараа 1860-аад оноос буюу Хятадад шинэчлэлийг дэмжсэн таатай уур амьсгал бүрдэх үед эхэлжээ. Тухайн үед гадны хязгаарлагдмал өөрчлөлт, нөлөөг оруулж ирэхийн тулд гадаад ертөнцөд үүд хаалгаа нээх шаардлагыг эрх баригчид ойлгосон байв. Үүнээс гадна 1858-1860 оны Өрнөдийн орнуудтай Хятад дахин мөргөлдөж газар нутагт нь шинэ аюул үүсч эхэлсэн юм. Ингээд олон улсын эрх зүйг зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх болсон байна. Ингэхдээ олон улсын эрх зүйн бүтээлүүдийг орчуулах, тодорхой гэрээ, хуулиудыг судлах болжээ.

²⁹⁰ The text was originally written in French with the title *Le Droit des Gens*. The Chinese texts appear to have been based on the 1833 (Joseph Chitty) English translation.

²⁹¹ A detailed study of these texts and their language is published in Svarverud (2000).

Олон улсын эрх зүйн нэр томъёог орчуулж эхэлсэн нь

Америкийн иргэн Уиллам Мартин (1827-1916) Хятадад анх 1850 онд шашны төлөөлөгчийн хувиар ирсэн ч удалгүй улс төр, олон улсын харилцааны чиглэлийн ажил хийх болсон байна. Тэрбээр шашны ажлаа орхиж Хэнри Витоны “Олон улсын эрх зүйн үндэс” бүтээлийг 1862 онд Хятад хэл рүү орчуулж эхэлсэн байна. Гэвч орчуулгын бүтээлийг хэвлүүлэхэд хүндрэлтэй тулгарчээ. Энэ үе Хятадын газар нутаг дээр Дани, Пруссийн эзэмшлийн маргааныг олон улсын эрх зүйд заасан зүйл заалтаар шийдвэрлэхтэй давхцсан байна. Тухайн зүйл, заалтыг Хятадын эрх баригчид болоод тус улсын ГХЯ (Zongli Yamen) Мартины хараахан хэвлэгдээгүй байгаа гар бичмэлээр олж мэдсэн ажээ. Ингээд удалгүй уг гар бичмэлийг Хятадад хэвлүүлэхээр болсон агаад ГХЯ уг бүтээлийг дуусгах ажлыг хариуцсан байна. Уг бүтээл нь *Wanguo gongfa* (Түмэн улсын нийтийн цааз) гэсэн гарчигтайгаар Бээжин хотын Цуншигуаны хэвлэлийн газарт 1864 онд хэвлэгдэн гарчээ. Удалгүй буюу 1865/1867 онд Мартиныг Бээжинд байгуулагдаад удаагүй байгаа Тунвэньгуан (Гадаад хэл, соёлын сургууль)-д олон улсын эрх зүй заах, энэ чиглэлийн бүтээл орчуулуулахаар ажилд авсан байна.

Тунвэньгуанд ажиллаж байх үедээ тэрбээр Хятад хамтран ажиллагсадтайгаа хамтран 1870, 1880-аад онд олон улсын эрх зүйн холбогдолтой олон ном орчуулсан бөгөөд бүгдийг нь энэ сургуулиас эрхлэн гаргасан байна. Эдгээр бүтээлд: 1876: Шарль де Мартинсийн *Manuel diplomatique* (Хятад хэлээр *Xingyao zhizhang*), 1877: Теодер Дуайт Вүлзигийн *Introduction to the Study of International Law (Gongfa bianlian)* 1880: Иоханн Каспар Блунтшлигийн *Volkerrecht der civilisierten Staaten als Rechtsbuch dargestellt (Gongfa huitong)* 1883: Гюстав Мойнегийн *Les Lios de la Guerre sur Terre (Ludi zhanli xinxuan)* 1884: Уиллиам Мартины *Traces of International Law in Ancient China (Zhongguo gushi gongfa lunlue)*

Сүүлд дурдагдсан энэхүү бүтээл нь Мартины өөрийнх нь бичсэн Жоугийн үеийн Хятадын улсуудын харилцааны талаарх бүтээл юм. Энэхүү бэсрэг бүтээлийг англи хэлээр анх хэвлүүлсэн агаад хожим Тунвэньгуан хятад хэл рүү хөрвүүлж хэвлүүлсэн байна. 1894 онд Тунвэньгуанаас гарч 1898 онд²⁹² Бээжин дэх Эзэн хааны их сургуулийн (Jingshi daxuetang) ерөнхийлөгч болсныхоо дараа Мартин мөн олон улсын эрх зүйн хоёр ч бүтээлийг орчуулсан байдаг. Гэхдээ түүнийг Тунвэньгуанд ажиллаж байх үед л хэвлэгдсэн бүтээлүүд нь Хятадад олон улсын эрх зүй нэвтрэхэд гол үүрэг гүйцэтгэсэн юм.

Хайгуо тужи-д орсон Ваттелын бүтээлийн орчуулагдсан хэсгийг бодвол Мартин олон улсын эрх зүйн онолын гүн гүнзгий агуулга бүхий бүрэн хэмжээний тайлбарыг орчуулах маягаар Хятад хэлэн дэх олон улсын эрх зүйн гол нэр томъёог буулгахаас аргагүйд хүрсэн байна. Түүний буулгасан хамгийн чухал үг бол “эрх” гэдэг үгийг *quanli* хэмээн орчуулсан юм. Эдгээр үгийг Мартин Тунвэньгуан дахь хамтрагчдынхаа хамт Хятад хэлэнд анхлан буулгажээ. Нэлээд олон тохиолдолд

²⁹² Martin also published, in Chinese, translations of the following works: William Edward Hall, *A Treatise on International Law* published in 1903 with the title *Gongfa xinbian*; and Martin's own lectures at the Hubei Mandarin Institute published in 1904 with the title *Bangjiao tiyao*.

эдгээр үгийг буулгахдаа Хятадын эртний сурвалжийг ашигласан байдаг ч утга зүйн шинэ агуулгыг оруулж өгсөн байна. Үүний нэг нь энэхүү *quanli* гэх үг юм. Тэд анхлан олон улсын эрх зүй гэдгийг Хятад хэлэнд *wanguo* (олон улс) *gongfa* гэж буулгасан бол олон улсын тусгай эрх зүйг *gongfa zhi sitiao*, *siquan zhi fa*, эсвэл *tongrong luli* гэж төрөл бүрээр тэмдэглэсэн ажээ. *Zhuquan* гэдэг үгээр бүрэн эрхт байдал гэдэг үгийг төлөөлүүлсэн бол, *zili*, *zizhu* гэдэг үгээр тусгаар тогтнол гэдэг үгийг буулгасан байна. Төвийг сахих гэдэг үгийг *juwai* гээд хүчний тэнцвэр гэдгийг *junshi zhi fa* хэмээн орчуулжээ. Үүрэг, хариуцлага гэдэг үгийг буулгахад тэд хүндрэлтэй тулгарч байжээ.

Олон улсын эрх зүйн холбогдолтой үгсийг орчуулж, орчуулгаар гарч ирсэн үгсийг улмаар Хятад дипломат ажиллагаандаа тогтмол хэрэглэн Тунвэньгуанд олон улсын эрх зүйг заах болсноор Хятадад уг судлагдахууны онол, үгсийн сан сэхээтнүүдийн тодорхой хүрээнд нөлөөтэй болж иржээ. Европт шинээр байгуулагдсан Хятадын төлөөлөгчийн газар эдгээр бүтээлийг ашиглаж ажлаа явуулах болсон агаад 1870-аад оноос олон улсын маргаанд Хятадыг төлөөлөхөд тун чухал үүрэг гүйцэтгэх болсон байна. Олон улсын эрх зүйн маргааны талаар Хятадын сэхээтнүүдийн бусад төлөөлөл дунд томоохон хэмжээний хэлэлцүүлэг тухайн үед байсангүй. Цөөн хэдэн эрдэмтэд олон улсын асуудлаар санал бодлоо илэрхийлэхдээ олон улсын эрх зүйг хааяа нэг дурддаг байсан боловч Хятадын сэхээтнүүдийн дунд өргөн хэмжээний хэлэлцүүлгийн хэмжээнд уг судлагдахуун болж орж ирээгүй байв. Иймээс ч Зүүн Ази болоод олон улсын хамтын нийгэмлэгт Хятад улсын эзлэх байр суурийн тухай онолын үндэс тавигдах хараахан болоогүй байжээ. Энэ үзэгдэл 1890-ээд оны дунд үед Азийн хүчний харьцаанд гарсан өөрчлөлтийн үрээр бий болсон юм. Түүнээс өмнө Тунвэньгуанаас гадна Шанхайд л орчуулгын бүтээлүүд гарч байв.

Хоёр дахь урсгал

Жонн Фрайер (1839-1928) мөн Мартины нэгэн адил шашны номлогчийн хувиар Хятадад анх ирсэн ч Өрнөдийн мэдлэгийг нэвтрүүлэх үйлсэд удахгүй нэгджээ. Шанхай руу 1865 онд шилжихээс өмнө тэрбээр Бээжинд Тунвэньгуанд англи хэлний багшаар түр зуур ажилласан байна. Фрайер 1868 онд Зяннаний зэвсгийн агуулахын Орчуулгын хэлтэст ажилд орсон ажээ. Энэ нь Тунвэньгуанд *Wanguo gongfa* хэвлэгдээд дөнгөж дөрвөн жил болж байсан үе юм. Зяннаний зэвсгийн агуулах нь голдуу байгалийн шинжлэх ухаан, технологийн чиглэлийн орчуулгыг хийдэг байв. Уг агуулахад удаан хугацаагаар ажиллахдаа Фрайер хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн бүтээлийн тоог улам нэмэгдүүлсэн байна. 1880, 1890-ээд онд тус агуулахад ажиллаж байсан Фрайер ба түүний хятад нөхөд цөөн тооны буюу нэг богино өгүүлэл, дөрвөн боть олон улсын эрх зүйн бүтээл дээр ажиллаж эхэлсэн ажээ. Энэ хоёр орчуулга хийгдээд арай богино нь буюу Британника тольд орсон Эдмунд Робертсоны “Олон улсын эрх зүй” өгүүлэл нь түрүүлж орчуулагдаж дуусчээ. Бэсрэг хятад товхимол 1886-1894 оны хооронд Зяннаний агуулахад *Gongfa zonglun* нэртэйгээр хэвлэгдэж гарсан байна. Роберт Филлиморын “Олон улсын эрх

зүйн тухай” нэртэй дөрвөн боть бүтээлийг Зяннаний агуулахын орчуулгын баг орчуулж байв. Олон улсын эрх зүйтэй холбогдох эхний гурван боть бүтээл 1894 онд *Geguo jiaoshe gongfa lun* нэртэйгээр гарсан бол дөрөв дэх боть нь 1898-1902 оны хооронд тусгай эрх зүйн сэдвээр хэвлэгдэлгүй хүлээгдсэн байна. Сүүлийн боть нь *Geguo jiaoshe bianfa lun* гэсэн өөр гарчигтайгаар хэвлэгджээ. Агуулахад Фрайер ажиллахаа больсон ч гэсэн Хятадад байхдаа олон улсын эрх зүйн бас нэг бүтээл орчуулжээ.²⁹³

Бээжинд хамтран ажиллаж байсан Мартины нэгэн адил 1860-аад онд Тунвэньгуанд аль хэдийн тогтсон байсан орчуулгын үгс, техникийг ашиглан олон улсын эрх зүйн бүтээлийг үргэлжлүүлэн Хятад хэл рүү Фрайер орчуулсан нь мэдээжийн хэрэг байв. Гэхдээ тэрбээр Шанхайд Тунвэньгуанаас өөрөөр олон улсын эрх зүйн нэр томъёог буулгах болсон байна. Тэрбээр Мартины анхлан буулгасан *zhuquan* (бүрэн эрхт байдал), *zili, zizhu* (тусгаар тогтнол), *juwai, zhongli* (төвийг сахих) гэдэг үгсийг хэвээр нь хэрэглэсэн байна. Харин эрх гэдэг үгийг *fen suo dang de*, үүрэг, хариуцлага гэдэг үгийг *fen suo dang xing* ба *feng suo dang wei* гэж өөрөөр буулгажээ. Олон улсын (нийтийн, эсвэл түгээмэл) эрх зүйг *jiaoshe gongfa*, тусгай (хувийн) эрх зүйг *jiaoshe bianfa* буюу Филлиморын бүтээлийн гарчгаар буулгасан байна. Хүчний тэнцвэр гэдгийг *pingquan zhi li* гэж буулгажээ. Энэхүү богино жагсаалтаас харахад Мартины хараахан буулгаж чадаагүй зарим үгсийг Фрайер гүйцээсэн гэдэг нь олон улсын тусгай эрх зүй, үүрэг/хариуцлага гэдгийг хэрхэн буулгаснаас нь харж болно. Гэхдээ нэг үгийг ийм олон маягаар орчуулсан нь 1890-ээд онд олон улсын эрх зүй судлаачдыг төөрөгдөлд оруулж байсан байх магадлалтай. 1890-ээд оны дунд үеэс Хятадын олон улсын байр суурийг сонирхсон анхаарал нэмэгдэх үед энэхүү төөрөгдөл ил болж эхэлсэн байна.

Хятадын олон улсын байр суурийн талаарх асуудал

1894-1895 оны Хятад-Японы дайн Зүүн Ази дахь хүчний тэнцвэрийг өөрчилсөн юм. Өмнө нь Зүүн Азид өөрсдөөс нь мэдлэг, соёлоо авдаг байсан Японы ард түмэн Хятадыг ялсан явдал Хятадын олон түмэнд маш том цохилт болсон байна. Япон тухайн үед Мэйжийн шинэчлэлийн хүрээнд орчин үеийн боловсролыг нэвтрүүлээд удсан байв. Япон үүний үр дүнд дан ганц цэргийн бус улс төр, эдийн засаг, боловсрол болоод соёлынхоо нийгмийн салбарт илүү “шалгарсан” байжээ. Зүүн Азид олон жилийн тогтвортой байдал гэнэт үгүй болж, олон зууны турш тус бүс нутагт оршоор ирсэн Япон-Хятадын уламжлалт харилцаа өөрчлөгдөж ирсэн байна. Японы шинэ дүр төрхөөс Хятадын сэхээтнүүд эмээж байсан боловч өөрийн гэсэн хэв загвараар шинэчлэл хийж байгааг нь шимтэн сонирхож байв. Дайны дараах олон улсын харилцааны талаарх хэлэлцүүлэг тэр чигтээ өөрчлөгдсөн байна. Үүний улмаас Хятадад олон улсын эрх зүй нэвтрэхэд хоёр гол нөлөөг тэр даруй үзүүлсэн юм. Эхнийх нь 1890-ээд оны сүүлээр Хунань мужид үүссэн шинэчлэлийн хөдөлгөөнөөр тодорхой болсон байна. Шинэчлэлийн төлөөх

²⁹³ Fryer also translated the work *Manual of International Law* by Jan Helenus Ferguson into Chinese with the title *Bangjiao gongfa xinlun*. It was published by the Gezhi shushi in Shanghai in 1901.

албан тушаалтан, сэхээтнүүд болох Лян Цичао, Тан Цайчан (1867-1900), Тан Ситун (1865-1898) тэргүүтэй улсууд Чаншад боловсрол, нийгмийн шинэчлэлийг турших замаар улмаар Хятад даяар шинэчлэлийг хийх зорилготойгоор цугларсан байна (Ding 2000). *Xiangbo* ба *Xiangxue* гэх мэт тухайн цаг үед хэвлэгдэж байсан хэвлэлээс харвал улс хоорондын харилцааны талаарх Хятад ойлголттой олон улсын эрх зүйг нэгтгэх гэж ихээхэн чармайж байсан гэдэг нь илт байгаа юм. Тан Цайчан ялангуяа үүнд голлох үүрэг гүйцэтгэсэн агаад Хятадын олон улсын байр суурийг тодорхойлох зорилгоор хэд хэдэн цуврал өгүүлэл олон улсын эрх зүйн сэдвээр бичиж байв. Тэрбээр өгүүллээ бичихдээ Тунвэньгуан болоод Зяннаний зэвсгийн агуулахаас эрхлэн гаргасан бүтээлүүдийг ашигласан байна. Олон улсын харилцааны асуудал, Хунаньд орчин үеийн боловсролын систем бий болгох тухай түүний бичлэгээс харвал олон нэр томъёо тухайн үед түүний шавь, уншигчдад төөрөгдөл авчирч байсан гэдэг нь илэрхий байгаа юм. Гэхдээ Хятадын олон улсын байр суурийг тодорхойлох гэсэн Хунаньд хийсэн энэхүү оролдлого түр зуурын зүйл байжээ. Иймэрхүү түр зуурын төөрөгдөл тодорхой нэг стандартын нэр томъёог хүлээж авч илүүдэл хэсгийг хассанаар яваандаа арилах учиртай байдаг. Гэтэл ийм зүйл болоогүй юм. Шинэчлэл, модернизацийн холын нэгэн загварын түүчээ болж байсан Япон бас нэгэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Японы нөлөө

Шимоносекийн энхийн гэрээ байгуулагдмагц маш олон тооны Хятад залуучууд Япон руу орчин үеийн боловсрол эзэмшихээр явцгаасан юм. Энэ нь орчин үеийн боловсролын тогтолцоог нэвтрүүлэх гэсэн Хятадын албан ёсны оролдлого байв. Гэвч Японд сурч байгаа хятад оюутан, эрдэмтдийн улс төр, нийгмийн үзэл санааг хөгжүүлэх талбар болон хувирч Хятадын удирдагчдын хяналтаас гарчээ. Хятадын Засгийн газар уг хөтөлбөрөө зогсоохыг оролдсон боловч нэгэнт хожимдсон байсан төдийгүй илүү олон тооны хятадууд өөрсдийн санаачлагаараа Япон руу суралцахаар явах болжээ (Hartell 1992). Хэлний хувьд бэрхшээл гэх зүйл байсангүйн дээр шинэчлэлийн төлөө бодолтой залуу сэхээтнүүдэд Хятадыг бодвол тухайн үеийн Японы улс төрийн орчин хамаагүй нээлттэй, олныг хамарсан шинжтэй байв. Японд боловсрол олж авсан хэдэн мянган Хятад оюутан тус орны уран зохиол, нийгэм-улс төрийн хэлэлцүүлгийг сонирхож байсны дотор олон улсын эрх зүй судлал хэрхэн хөгжсөн явдал орж байв. Тунвэньгуан болоод Зянаний зэвсгийн агуулахад дөч гаруй жилийн турш орчуулагдсан олон тооны бүтээлийн талаар Японд хуулиар суралцаж буй Хятад оюутнууд ойлголтгүй байсан тул олон улсын эрх зүйн Японы уламжлалыг тэр даруй хүлээж авч байв. Тэд олон тооны өгүүлэл, ном цуглуулан орчуулахын сацуу Японы их, дээд сургуулиудын лекцийн материалуудыг эмхэтгэдэг байжээ. 1902 оноос эхлээд эдгээр зүйл албан ёсоор хэвлэгдэх болж, Хятадад олон улсын эрх зүй судлалын гурав дахь давалгаа болон хувирсан байна. 1902 оноос 1911 онд Чин улс нурах хүртэлх цөөн хэдэн жилд Японд суралцсан оюутнуудын бүтээсэн 50 гаруй ном Хятадад хэвлэгдсэн байжээ. Ийм их хэмжээний бүтээл гарах үетэй Хятадын олон улсын байр суурь ганхаж таарсан тул тухайн үеийн бүтээлийн агуулгад нөхцөл байдал хүчтэй нөлөөлж байжээ.

Мартин, Фрайер нарын санаачилсан болоод шилжилтийн үеийн²⁹⁴ цөөн хэдэн бүтээлийг эс тооцвол 1902 оноос эхлээд Хятад хэлээр гарсан олон улсын эрх зүйн бүтээлийн зах зээлийг Японд хийсэн бүтээлүүд давамгайлах болсон байна. 1860, 1870-аад онд Тунвэньгуанд хийгдэж байсан олон улсын харилцааны бүтээлийг бодвол 1880, 1890-ээд оноос Зүүн Азийн нөхцөл байдал цаашлаад дэлхий ертөнцийн байдлын тухай илүүтэй сонирхох болжээ. Энэ үе нь Японоос улс төр, оюун санаа, соёлын маш том түрэлт орж ирсэнтэй давхцсан төдийгүй Хятад хэлний орчуулгын үгсийн санд Япон хэлний хэл зүйн нөлөө тэр даруй тусах болсон байна. Япон хэлний орчин үеийн шинжлэх ухааны бүхий л үгсийг Япон ханзаар тэмдэглэгдгийн сацуу олон тохиолдолд Хятад үгийн үндэс дээр тулгуурласан байдаг. Хятад мөн адил ханз хэрэглэдэг тул Японд суралцаж байсан Хятад оюутнууд эдгээр үгсийн санг түвэггүй нэвтрүүлж байв. Үүний улмаас Тунвэньгуан, Зянаный зэвсгийн агуулахад орчуулсан олон улсын эрх зүйн техникийн нэр томъёо хэрэггүй болж, Японд хэвлэгдээд Хятадад оруулж ирж байсан бүтээлд орсон ханзанд суурилсан үгс шууд хэрэглэгдэх болжээ. 1860, 1870-аад онд Мартинь анх буулгаж байсан цөөн тооны нэр томъёо болох *quanli*, *zhuquan* гэх мэт л тухайн үед Японд нэвтэрч хэрэглэгдэх болсон байна. Харин бусад үгсийн хувьд олон улсын эрх зүйн Япон хэлний үгсийн сан давамгайлах болжээ. Олон улсын түгээмэл эрх зүй *guoji gongfa* болсон бол тусгай эрх зүй нь *guoji sifa* хэмээн шинээр нэрлэгдэх болсон байна. Тусгаар тогтнол гэдэг *duli*, төвийг сахих гэдэг үг *zhongli* хэмээн тогтвортой хэрэглэгдэх болжээ. Үүрэг/хариуцлага гэдэг үгийг Японоос оруулж, *yiwu* гэж нэгэнт тогтохоор болсон байна. Хятад хэлэнд өмнө нь огт байгаагүй ойлголтуудыг мөн Япон хэлнээс шууд оруулж ирэх болсон байна. Энэ үгс дотор extraterritoriality буюу суугаа орны хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх гэдэг үгийг *zhiwai faquan* гэж оруулсан байна.

Хятадын талаарх шинэ хэлэлцүүлэг

1880, 1890-ээд онд Хятадын олон улсад эзлэх байр суурийн талаарх хэлэлцүүлэг тун явцуу хүрээнд өрнөж байсан тухай өмнө нь дурдсан билээ. Хунаний хөгжлийн төлөөх хөдөлгөөнөөр л зарим нэг хэлэлцүүлэг өрнөж байсан гэдгийг бид харсан. Харин XX зууны эхэн үед Японы нөлөөгөөр Зүүн Азид бий болсон нөхцөл байдлын үрээр энэхүү хэлэлцүүлэг маш өргөн хүрээтэй болж ирсэн юм. Социаль Дарвинизм болоод Хятадын эртний сонгодгууд болох Луньюй, Мэнз, Сүнз, Лаоз нарын бүтээлийг Хятадын эрдэмтэд ашиглаж, Хятадын уламжлал, эволюцийн дэвшил ба дэвшлийн төлөөх тэмцэл, олон улсын эрх зүйн шинэ чиг хандлагын хооронд байгаа зөрүүг тайлбарлахыг оролдож байв. 1904-1905 оны Манжуур дахь Хятадын газар нутгийн төлөө Зүүн Азид Орос, Япон хоёр дайн хийх үед буюу олон улсын харилцааны шинэ нөхцөл байдал Хятадын хаалгыг тогших үед тэрхүү зөрүү тэр даруй алга болсон байна. Уг маргааны үеэр олон улсын эрх зүйн хүрээнд Хятад төвийг сахих нь зөв гэсэн байр суурь хааны ордон болоод сэхээтнүүдийн

²⁹⁴ Such as a text by Ding Zuyin entitled *Wanguo gongfa shili* published in Jiangsu in 1898; a translation of a text by Arthur Desjardins translated into Chinese and published with the title *Zhina guoji lun* in Shanghai/Tokyo in 1902; and a Chinese translation of Thomas Joseph Lawrence's book *A Handbook of Public International Law* published with the Chinese title *Wanguo gongfa yaolie* in Shanghai in 1903.

дунд давамгайлж байв. Энэ асуудлаар Дарвин, Күнз, Лаозын онол, сургаал Гроций болоод Өрнөдийн бусад сэтгэгчдийн бүтээлд зайгаа тавихаас аргагүйд хүрч байв. Үүний үр дүнд уг хэлэлцүүлэг олон улсын эрх зүйн онолын болоод процедурын нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн чиглэлд хувирсан байна. Зүүн Азийн уламжлалт байдал улс төр болоод оюун санааны түвшинд бүр мөсөн өөрчлөгджээ.

Хятад олон улсын тавцанд ийнхүү хөл тавьж, Европын улсуудтай бүрэн эрхт улсын хүрээнд хэлэлцээ явуулж эхэлсэн тул олон улсын харилцааны Өрнөдийн хэлэлцүүлгийн нэгэн чухал хэсэг яах аргагүй Дундад улс болсон юм. Олон улсын эрх зүйгээр дамжуулан Япон нь Өрнөдийн эрх зүй судлалын эрдэмтэдтэй харилцаа тогтоогоод байв. 1894-1895, 1904-1905 оны Зүүн Ази дахь дайнуудаар Японы олон улсын эрх зүйчид улсынхаа үйлдэл, санаа зорилгыг тайлбарлах хангалттай үндэслэлтэй болсон байв. Харин Өрнөд Хятадыг тун таагүй байдлаар авч үзэж байв. Олон улсын эрх зүйн хүрээнд Хятадын байр суурийг авч үзсэн Өрнөдийн иймэрхүү хандлага олон жилийн турш амь бөхтэй байсан тул олон улсын хамтын нийгэмлэг Дундад улсыг ойлгож хүлээж авахад урт хугацааг зарцуулжээ. Ма Деруны зохиож, 1907 онд Англи, Герман хэлээр хэвлүүлсэн “Хятад олон улсын эрх зүйг дагаж мөрдөж буй нь” гэх бүтээлээр л Хятад улс хоорондын харилцаагаа явуулахдаа хэрхэн олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаа тухайгаа Өрнөдөд ойлгуулсан юм. Хятадад олон улсын эрх зүйг нэвтрүүлснээр тус улс бүрэн эрхт улсуудын нэгэн адил эрхийг өөрсдөөс нь шаардана хэмээн анхандаа Өрнөдийн эрх баригчид болгоомжтой хандаж байв. Тэр цаг ирсэн ч гэлээ Европ дахь олон улсын эрх зүй судлалаар мэргэшсэн хүмүүс Хятадыг олон улсын хамтын нийгэмлэгийн нэгэн гишүүн гэж хүлээн зөвшөөрөх сонирхолгүй л байлаа.

ДҮГНЭЛТ

1840-өөд онд олон улсын эрх зүй хэмээх системийн оршин байдаг тухай ойлголтгүй байсан Хятадын төр, сэхээтнүүд Чин улсын төгсгөл үед олон улсын харилцааг ойлгох нэг систем болгон нэвтрүүлсэн байна. Зүүн Азийн улс хоорондын харилцааг зохицуулдаг байсан уламжлалт тогтолцоо олон улсын эрх зүйн улсын бүрэн эрх, хүчний тэнцвэр гэх зүйлсээр солигдов. Мөн үүний зэрэгцээ улс хоорондын харилцааг тайлбарласан бусад ойлголтууд ч нэвтэрч эхлэв. Чин улсын төгсгөл үеийн Хятадын сэхээтнүүд эх орноо олон улсын эрх зүйд тодорхойлсон бүрэн эрхт гишүүн гэж хараахан үзэж эхлээгүй байжээ. Нөгөө талаар Өрнөдийн орнууд ч гэсэн онолын болоод практик түвшинд Хятадыг аажмаар олон улсын бүрэн эрхт гишүүн гэж хүлээн зөвшөөрсөн. Ийнхүү 1912 онд Хятадад байгуулагдсан шинэ засгийн газрын олон улсын харилцааны онолын үндэс нь тавигдсанаар тус улсын цаашдын олон улсын харилцааг ойлгох үндэс бүрэлджээ.

НОМ ЗҮЙ

1. Dikötter, Frank (1992) *The Discourse of Race in Modern China*, London: Hurst & Company.
2. Ding, Pingyi (2000) *The History of the Hunan Reform Movement from 1895 to 1898 1895 1898*, Taipei: Han-Chung Book Co. Ltd .
3. Fairbank, John King (1953) *Trade and Diplomacy on the China Coast: The Opening of the Treaty Ports, 1842–1854*, Stanford: Stanford University Press.
4. Gong, Gerrit W. (1984) ‘China’s entry into international society’. In Hedley Bull and Adam Watson (eds.) *The Expansion of International Society*, Oxford: Clarendon Press, 171–183.
5. Harrell, Paula (1992) *Sowing the Seeds of Change: Japanese Students, Japanese Teachers, 1895–1905*, Stanford, CA: Stanford University Press.
6. Hsü, Immanuel C. Y. (1960) *China’s Entrance into the Family of Nation: The Diplomatic Phase 1858–1880*, Cambridge, MA: Harvard University Press.
7. Hughes, E.R. (1968) *The Invasion of China by the Western World*, London: Adam and Charles Black.
8. Huntington, Samuel (1996) *The Clash of Civilizations and the Remaking of World Order*, New York: Simon & Schuster.
9. Iriye, Keishiro (1967) ‘The principles of international law in the light of Confucian doctrine’, *Recueil des cours (Académie de droit international de la Haye)* 120: 1–58.
10. Lin, Xuezhong (2010) *From the Law of Nations to International Diplomacy: The Introduction, Interpretation and Application of International Law in Late Qing Times —*, Shanghai: Shanghai guji chubanshe.
11. Liu, Lydia H. (2004) *The Clash of Empires*, Cambridge, MA and London: Harvard University Press.
12. Mancall, Mark (1971) *Russia and China: Their Diplomatic Relations to 1728*, Cambridge, MA: Harvard University Press.
13. Martin, W.A.P. (1882) ‘Traces of international law in ancient China’, *Congrès des Orientalists* 22(2): 71–78.
14. Morse, Hosea Ballou (1971) *The International Relations of the Chinese Empire*, Taipei: Ch’eng wen Publishing Company.
15. Pomeranz, Kenneth and Topik, Steven (2006) *The World that Trade Created: Society, Culture, and the World Economy 1400 to the Present*, New York: M.E. Sharpe.
16. Pusey, James Reeve (1983) *China and Charles Darwin*, Cambridge, MA: Harvard University Press.
17. Qi, Qizhang (2001) *The Sino-Japanese War (1904–05) Seen From the Perspective of International Law*, Beijing: Renmin chubanshe.
18. Svarverud, Rune (2000) ‘Jus Gentium Sinense: the earliest Chinese translation of international law with some considerations regarding the compilation of *Haiguo tuzhi*’, *Acta Orientalia* 61: 203–237.
19. Svarverud, Rune (2007) *International Law as World Order in Late Imperial China: Translation, Reception and Discourse, 1847–1911*, Leiden: Brill.
20. Tian, Tao (2001) *The Introduction of International Law and late Qing China*, Jinan: Jinan chubanshe.
21. Tuck, Richard (1999) *The Rights of War and Peace: Political Thought and the Interna-*

- tional Order from Grotius to Kant*, Oxford: Oxford University Press.
22. Walker, Richard Louis (1971) *The Multi-State System of Ancient China*, Westport, CT: Greenwood Press.
 23. Wang, Ermin (1998) *The Treaty Diplomacy in Late Qing*, Hong Kong: Zhongwen daxue chubanshe
 24. Wang, Tieya (1991) 'China and international law – history and present', *Chinese Yearbook of International Law* 1991: 5–115.
 25. Wills, John E. (2005) *Pepper, Guns, and Parleys: The Dutch East India Company and China, 1662–1681*, Los Angeles: Figueroa Press.
 26. Wong, R. Bin (1997) *China Transformed: Historical Change and the Limits of European Experience*, Ithaca and London: Cornell University Press.
 27. Zhang, Jingcao (1992) 'How Western international law was introduced into China and its influence upon China'. In Bernard H.K. Luk (ed.) *Contacts Between Cultures: Vol. 4: Eastern Asia: History and Social Sciences*, Lewiston: Mellen, 264–270.
 28. Journal: Inter-Asia Cultural Studies
 29. Issue: Vol. 12, Number 2
 30. Year: 2011
 31. Article name: Re-constructing East Asia: international law as inter-cultural process in late Qing China
 32. Author: Rune Svarverud